



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн “Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/006/-НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.open.audit.mn

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Аудитор Н.Дашмягмар

Утас: 99164665

Цахим хаяг: Dashmyagmarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын тайлан	5
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	7
5.2 Албан шаардлага.....	8

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
БОУАӨС	Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайд
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ТБОНХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.08.14 № 145
танай _____-ны № _____-т

“ЧУЛУУТ-АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Ч.ЧИМЭДДЭЛЭГ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Чулуут-Ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Тайлант онд бизнес төлөвлөгөөнд тусгаагүй анхан шатны баримтгүй 350,000 төгрөг, тушаал, шийдвэргүй шагнал урамшуулалд 800,000 төгрөг, нийт 1,1150,000 төгрөгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан;
2. Өр авлагыг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй;

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8,800.00	54,846.00
1.1.2	Дансны авлага	2,562,000.00	2,965,205.00
1.1.6	Бараа материал	3,527,200.00	1,241,100.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	6,098,000.00	4,261,151.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,085,347,096.66	1,062,205,860.66
1.2.9	Бусад үндсэн хөрөнгө	810,640.00	709,310.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,086,157,736.66	1,062,915,170.66
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,092,255,736.66	1,067,176,321.66
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	6,297,769.42	5,550,376.98
2.1.1.1	Дансны өглөг	1,915,843.44	
2.1.1.3	Татварын өглөг	1,521,306.55	706,378.65
2.1.1.5	НӨАТ-ын өглөг	2,860,619.33	4,843,998.33
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,297,769.42	5,550,376.98
2.20	Өр төлбөрийн нийт дүн	6,297,769.42	5,550,376.98
2.3.1	а) төрийн	1,261,748,800.00	1,261,748,800.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	19,240,890.00	19,240,890.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(195,031,722.77)	(219,363,745.32)
2.3.10	Өмнөх үеийн ашиг (алдагдал)	(170,978,019.42)	(195,031,722.76)
2.3.11	Тайлант үеийн ашиг (алдагдал)	(24,0543,703.35)	(24,332,022.56)
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,085,957,967.23	1,061,625,944.68
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,092,255,736.66	1,067,176,321.66

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
4	Түрээсийн орлого	42,600,269.00	57,763,989.00
7	Хандив тусламжийн орлого	20,000,000.00	20,000,000.00
8	Бусад орлого	25,158,249.00	21,700,506.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	111,812,221.35	111,218,617.56
12	Бусад зардал		12,577,900.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(24,053,703.53)	(24,332,022.56)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(24,053,703.53)	(24,332,022.56)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(24,053,703.53)	(24,332,022.56)
24	Орлогын нийт дүн	(24,053,703.53)	(24,332,022.56)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	90,033,407.00	104,801,121.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	44,403,296.00	61,960,615.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	20,000,000.00	20,000,000.00

1.1.5	Үйл ажиллагааны орлого	25,630,111.00	21,700,506.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		1,140,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	90,081,961.86	104,755,075.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	29,519,900.00	34,674,328.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,072,719.00	4,608,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,009,200.00	1,430,600.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	17,325,769.82	25,961,919.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	31,919,373.89	31,911,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,074,046.16	4,961,528.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,160,953.00	1,207,700.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(48,554.86)	46,046.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(48,554.86)	46,046.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	57,354.86	8,800.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,800.00	54,846.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	ҮЗҮҮЛЭЛТ	Халаасны хувьцаа	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,261,748,800.00	19,240,890.00	(195,031,722.76)	1,085,957,967.24
3	2024 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	1,261,748,800.00	19,240,890.00	(195,031,722.76)	1,085,957,967.24
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(24,332,022.56)	(24,332,022.56)
9	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,261,748,800.00	19,240,890.00	(219,363,745.32)	1,061,625,944.68

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

ДД	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Түрээсийн орлого	58,344,000.00	63,066,615.00	4,722,615.00	108%
2	Халуун усны орлого	7,150,000.00	5,294,698.00	(1,855,302.00)	74%
3	Хогны хураамжийн орлого	13,400,000.00	8,844,000.00	(4,556,000.00)	65.9%

4	Сэг зэм устгах орлого ОНХСан	20,000,000.00	20,000,000.00	-	
5	Өрхийн хэрэглээний усны орлого	7,900,000.00	7,595,808.00	(304,192.00)	96.1%
6	Их засвар	20,000,000.00	-	-	
Нийт орлогын дүн		126,794,000.00	104,801,121.00	(21,992,879.00)	82.6%
1	Үндсэн ба нэмэгдэл цалин, НДШ	42,500,000.00	44,243,855.00	(1,743,855.00)	104%
2	Цахилгаан өөрийн хэрэглээ	11,950,000.00	11,811,918.54	138,081.46	98.8%
3	Түлш, шатахуун, тээврийн зардал	12,110,000.00	12,828,400.00	(718,400.00)	105%
4	Засвар, үйлчилгээний зардал	20,000,000.00	6,504,700.00	13,495,300.00	32.5%
5	Сэг зэм устгалын зардал	20,000,000.00	12,577,900.00	7,422,100.00	62.8%
6	Хог хаясны зардал бохир зайлуулах зардал	7,000,000.00	14,150,000.00	(7,150,000.00)	202%
7	Бусад зардал	13,045,000.00	2,638,300.02	10,406,699.98	20.2%
Нийт зарлагын дүн		126,605,000.00	104,755,073.00	(21,849,927.00)	82.7%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,150.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрснээс 350.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 800.0 төгрөгийн зөрчлийг арилгах, ер авлагыг барагдуулах албан шаардлагыг тус тус хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 1,150.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 733.6 мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд бизнес төлөвлөгөөнд тусгаагүй 350.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөх нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.9-д "Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор хүргүүллээ.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант онд тушаал, шийдвэргүйгээр албан хаагчдын урамшуулалд 800.0 мянган төгрөг, нийт 800.0 мянган төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “Сахилга баттай байх”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

5.2.1 Өр авлагыг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 “Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Зөрчлийг арилгаж холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	350.0	1	350.0									
Тайлант онд тушаал шийдвэргүйгээр 800.0 мянган төгрөг зарцуулсан	1	800.0			1	800.0							
Өр авлагыг бүрэн барагдуулах арга хэмжээ авах	1	-			1	-							
Дүн	3	1,150.0	1	350.0	2	800.0							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.